

Ёслолууд ба гэрээнүүд ГЭЖ ЮУ ВЭ?

Ёслол нь баптисм, ариун ёслол гэх мэт санваарын эрх мэдлээр гүйцэтгэдэг ариун нандин зан үйл юм. *Гэрээ* нь чиний санваарын ёслолоор дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэй хийдэг амлалт юм. Ёслолууд ба гэрээнүүд нь биднийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой илүү ойр болоход тусалдаг. Ирээдүйд чи ариун сүмд илүү олон гэрээ байгуулах боломжтой.

- Энэ нь Вануатугийн анхны ариун сүм байх болно!
- Энэ нь тус улсын 80 арлын нэг болох Эфатэ арал дээр баригдана.
- Өөр хамгийн ойр ариун сүм 1127 километрийн зайд буюу Фиждид байдаг.



Вануатугийн Порт
Вила ариун сүм

- Энэ нь Тонгагийн хоёр дахь ариун сүм байх болно.
- Тонгад анхны номлогчид 1891 онд очжээ. Одоо тэнд олон гишүүн байдаг.
- Тонгагийн хаан хатан хоёр ариун сүмийн барилгын шав тавих ёслолд ирсэн.



Тонгагийн Нэйафу
арин сүм



*Картуудыг хайчилж аваад, тасархай зураасны дагуу нугалж, нийлүүлэн наа.
Бусад ариун сүмийн картуудыг friend.ChurchofJesusChrist.org-оос үзнэ үү.*